

Гарчиг

ОРШИЛ

ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

НЭГ. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

I.1 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

I.2 Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

ХОЁР. 2016 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ҮР ДҮН

II.1. Малтай өрх болон малчин өрх, малчдын тоо, тэдний ахуйн зарим үзүүлэлт

II.1.1 Малчдын тоо, насны бүлэг

II.1.2 Малчдын соёл, ахуйн нөхцлийн үзүүлэлт

II.2. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн

II.2.1 Малын тоо

II.2.2 Сүргийн бүтэц

II.2.3 Иргэдийн хувийн малын тоо

II.2.4 Хээлтэгч мал

II.2.5 Төл бойжилт

II.2.6 Том малын зүй бусын хорогдол

II.2.7 Малын хээл хаялт, сувайралт

II.2.8 Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

II.2.9 Малын хэрэглээний зарлага

II.3. Тэжээвэр амьтад

II.4. Сум, багийн дундаж үзүүлэлт

II.4.1. Малжуулалтын талаарх мэдээлэл

II.5. Худаг, усан сангийн тоо, усжуулалтын талаархи мэдээлэл

ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТУУД

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр
- Хүснэгт 2. Газар тариалангийн үйлдвэрлэл
- Хүснэгт 3. Малтай өрх, малчин өрх, малчдын тоо
- Хүснэгт 4. Малчин өрхийн ахуй соёлын үзүүлэлт
- Хүснэгт 5. Малтай өрхийн ам бүлийн тоо, тэдгээрийн малын тоо, /2000-2017 он, мян, тол /
- Хүснэгт 6. Иргэдийн хувийн малын бүлэглэлт 2015, 2016, 2017 Он
- Хүснэгт 7. Малын тоо /мян, тол/
- Хүснэгт 8. Сумдын нийт малын тоо, мянган толгойгоор
- Хүснэгт 9. Сүргийн насны ангилалын бүтэц /хувиар/
- Хүснэгт 10. Сумдын мал сүргийн бүтэц, хонин толгойд шилжүүлсэн хувиар
- Хүснэгт 11. Хээлтэгч малын тоо
- Хүснэгт 12. Төл бойжилт, мянган толгойгоор
- Хүснэгт 13. 100 эхээс бойжуулсан төл, тоогоор
- Хүснэгт 14. Том малын зүй бусын хорогдол, тоогоор
- Хүснэгт 15. Оны эхний малд зүй бусын хорогдлын эзлэх хувь
- Хүснэгт 16. Хээл хаясан болон сувайрсан эх малын тоо
- Хүснэгт 17. Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь
- Хүснэгт 18. Хээлтүүлэгч малын тоо
- Хүснэгт 19. Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо
- Хүснэгт 20. Малын нийт хэрэглээний зарлага /мян.тол/
- Хүснэгт 21. Оны эхний малд эзлэх хувь
- Хүснэгт 22. Хэрэглээний малын тоо /мян.тол/
- Хүснэгт 23. Тэжээвэр амьтдын тоо
- Хүснэгт 24. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо, ам бүл
- Хүснэгт 25. Шинээр гаргасан худгийн тайлан
- Хүснэгт 26. Засварласан худгийн тайлан

Зургийн жагсаалт

Зураг 1. Малчдын насны бүтэц

Зураг 2. Малчдын нийгэм, ахуйн нөхцлийг харуулах зарим үзүүлэлт

Зураг 3. 200 хүртлэх малтай өрхийн тоо.

Зураг 4. 1000-аас дээш малтай өрхийн тоо.

Зураг 5. Нэг саяас дээш мал тоолуулсан он, малын тоо, мянган толгойгоор

Зураг 6. Малын тоо, мянган толгойгоор

Зураг 7. Аймгийн нийт малд сумдын эзлэх хувь

Зураг 8. Нийт малын тоо.

Зураг 9. Мал сүргийн бүтэц хувиар, таван төрлөөр

Зураг 10. Бойжуулсан төл, мянган толгойгоор

Зураг 11. Том малын зүй бусын хорогдол, тоогоор

Зураг 12. Малын хээл хаялт, сувайралт

Оршил

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгдэж байдаг.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2017 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа. Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна. "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2017 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулав.

Энэ жилийн хувьд Монгол Улсын Засгийн газраас малчдын тэтгэвэрт гарах насыг 5 жилээр багасгах талаар төрийн бодлого хэрэгжиж байгаатай холбоотойгоор хөдөө аж ахуй, нийгмийн салбарын төлөвлөлтөд нарийвчилсан тоо мэдээллийн хэрэгцээ бий болсон юм. Иймд ҮСХ-ны даргын 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/185 тоот тушаалаар баталсан тооллогын маягтад малчдын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, эрчимжсэн мал ахуйтай холбоотой мэдээллийг шинээр нэмж тусгажээ. Өөрөөр хэлбэл мал аж ахуй эрхэлж буй малчин хүн бүрийн мэдээлэл статистикийн мэдээллийн санд орох болсноороо өмнөх жилүүдийн тооллогоос онцлог байлаа.

Энэхүү танилцуулгад мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн талаар тусгасан.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр -1 бод	6 хонь	- 1 бод
1 тэмээ - 1.5 бод	8 ямаа	- 1 бод

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ- 5 хонь	1 хонь - 1 хонь
1 адуу - 7 хонь	1 ямаа - 0.9 хонь
1 үхэр- 6 хонь	

Нас гүйцсэн мал.Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай , 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал, Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч.Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцуулсан үзүүлэлтийг оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно. Малын өсөлтийн **орлого талнь** төл бойжилт, **зарлага тал нь**хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь.Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 -гаар үржүүлнэ.

Бойжилтийн хувь.Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл.Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур – 20-25 Бух – 35-45

Азарга- 12-15 Хуц, Ухна - 25-30

Малын зүй бус хорогдолдөвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бусын хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент.Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс - 0.45

Таримал тэжээл - 0.35

Даршны ургамал - 0.25

Гар тэжээл, хужир шүү - 1.0

Төмс ногооны хаягдал - 0.22

Үр тарианы хаягдал - 0.9

Лай - 0.4

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал.Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.

2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.

3. Шүүст тэжээл- Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.

- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай гэж хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжөөсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай гэж тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ юм.

Хураасан талбай гэж тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээ юм.

Га-гийн ургац гэж талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамлын тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тэр талбайн нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно. / 1тн=10 цн=1000кг /

Нийт ургац нь тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

Эдийн засгийн бүсэд:

Баруун бүс - Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан

Хангайн бүс - Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг

Төвийн бүс - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг

Зүүн бүс - Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг

Улаанбаатар бүс - Улаанбаатар хот

НЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

I.1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл.2017 онд малчдын зах зээлд борлуулсан, дотооддоо хэрэглэсэн махны хэрэглээ өмнөх оноос 14.7 хувиар ноос, ноолуур 0.7 хувиар, арьс, шир 10.7 хувиар буурсан бол сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 21.4 хувиар нэмэгдсэн байна. Мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн тоо 2017 онд 655.3 мянга болж өмнөх оноос 26.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр

Бүтээгдэхүүн		2014	2015	2016	2017	2017 2016
Мах, амьдын жингээр	тн	20808.4	25191.9	26689.3	22771.5	85.3
Сүү	тн	20259.9	21130.0	18917.5	22968.7	121.4
Ноос, ноолуур	тн	1308.8	1453.0	1552.5	1542.1	99.3
Арьс, шир	мян.шир	327.2	396.1	399.7	357.0	89.3

I.2. Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Тайлант онд 5448.9 тн өвс хадлан 537.4 тн гар тэжээл, 943.5 тн хужир шүү болон бусад тэжээл бэлтгэсэн мэдээг өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 17.0 хувиар бага, гар тэжээл 4.1 дахин их хураан авсан байна.

Хүснэгт 2. Газар тариалангийн үйлдвэрлэл

	2014	2015	2016	2017	2017 2016
Өвс, хадлан, тн	3365.8	4161.2	6565.0	5448.9	83.0
Гар тэжээл, тн	201.3	129.4	129.5	537.4	415.0
Хужир, шүү, тн	185.7	209.2	204.8	943.5	460.7
Тариалсан талбай, га	78.9	77.8	80.5	98.4	122.3
Хураан авсан ургац, тн	449.9	539.9	466.9	446.7	95.7

ХОЁР. МАЛ ТООЛЛОГЫН ДҮН

II.1 Малчдын тоо, тэдний ахуйн зарим үзүүлэлт


II.1.1 Малчдын тоо, насны бүлэг

2017 оны жилийн эцэст тус аймагт малтай 5201 өрх тоологдсны 4169 өрх буюу 80.2 хувь нь малчин өрх, 1032 өрх буюу 19.8 хувь нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх байна. Өмнөх онтой харьцуулахад малтай өрх 60-р буюу 1.2 хувиар, малчин өрх 32-р буюу 0.8 хувиар нэмэгджээ. Малчин өрхийн ам бүлийн тоо нь 13.8 мянга болж нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 3.3 байна.

Хүснэгт 3. Малтай өрх, малчин өрх, малчдын тоо

	2014	2015	2016	2017	2017 2016
Малтай өрх	4824	5020	5141	5201	101.2
Малчин өрх	3777	3988	4137	4169	100.8
Малчдын тоо	7086	7221	7477	7232	96.7
үүнээс: 16-34 насны	2731	2680	2649	2516	95
35-59 насны	3561	3742	3955	3673	92.9
Тэтгэврийн насны	794	799	873	1007	115.3
Нийт малчдаас эмэгтэй	3158	3158	3257	3043	93.4
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	407	414	390	443	113.6

Зураг 1. Малчдын насны бүтэц



Мал аж ахуйн салбарт ажиллаж буй малчдын тоо 2010 оноос жилд дунджаар 0.99% хувиар өсөөз байна. 2017 онд малчдын тоо 7232 болсон нь өмнөх оноос 3.3 хувиар

буюу 245 хүнээр буурсан байна. Нийт малчдын 3043 буюу 42.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Насны бүлгээр авч үзвэл 34.8 хувь нь 16-34 насны, 50.8 хувь нь 35-59 насны, 13.9 хувь тэтгэвэрийн насны хүмүүс байна.

Малчин нэг өрхөд 443, нэг малтай өрхөд 379 толгой мал ногдож байгаа нь улсын дунджаас малчин өрхийнх 91, малтай өрхийнх 91 толгой малаар олон байна.


II.1.2 Малчдын ахуйн зарим үзүүлэлт

2017 оны мал тооллогоор аймгийн нийт малчин өрхийн 82.4 хувь нь цахилгаан эх үүсвэртэй, 70.8 хувь нь телевизортой, 50.7 хувь нь автомашинтай, 58.3 хувь нь мотоциклтэй, 99.6 хувь нь гар утас хэрэглэдэг гэсэн үр дүн гарчээ. Нийт өрхийн дүнд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад цахилгаан эх үүсвэртэй өрхийн тоо 0.1, мотоциклтой өрхийн тоо 7.1, гар утас хэрэглэдэг өрхийн тоо 44.0 пунктээр өсөж, телевизортой өрхийн тоо 0.4, автомашинтай өрхийн тоо 2.2 пунктээр буурсан байна. Аймгийн малчин өрхүүдийн автомашин, мотоцикль, тээврийн хэрэгслийн хэрэглээ улсын дунджаас 8.7-13.2 пунктээр, цахилгааны эх үүсгүүрээр хангагдсан байдал 0.8 пунктээр дээгүүр байгаа бол, телевизээр хангагдсан байдал улсын дундажтай адил байна

Хүснэгт 4. Малчин өрхийн ахуй соёлын үзүүлэлт

	Өрхийн тоо			2017 2016	Малчин өрхийн дүнд эзлэх хувь			Өсөлт бууралт (пунктээр)
	2015	2016	2017		2015	2016	2017	
Нийт малчин өрх	3988	4137	4169	100.8	100.0	100.0	100.0	-
Цахилгаантай	3289	3405	3436	100.9	82.5	82.3	82.4	0.1
Телевизортой	2961	2947	2953	100.2	74.2	71.2	70.8	-0.4
Автомашинтай	2244	2190	2114	96.5	56.3	52.9	50.7	-2.2
Мотоциклтэй	2158	2120	2429	114.6	54.1	51.2	58.3	7.1
Гар утастай	3223	3271	4151	156.9	80.8	79.1	99.6	20.5

Зураг 2. Малчдын нийгэм, ахуйн нөхцлийг харуулах зарим үзүүлэлт



II.13 Иргэдийн хувийн малын тоо

2017 онд аймгийн хэмжээгээр аминдаа малтай өрх 5201 тоологдсоны 80.2 хувь буюу 4169 нь малчин өрх байна. Иргэдийн хувийн малын тоо энэ онд 1971.2 мянган хүрсэн нь нийт малын 98.5 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 12.4 хувь буюу 218.2 мянган толгой малаар өссөн байна.

Хүснэгт 5. Малтай өрхийн ам бүлийн тоо, тэдгээрийн малын тоо, 2000-2017 он /мян.тол/


	Малтай өрхийн тоо	Ам бүлийн тоо	Бүгд	Үүнээс :				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2000	6283	24659	960.5	26.7	113.8	83.5	408.3	328.2
2005	5020	19018	933.5	26.3	77.5	43.3	352	434.4
2010	4460	15593	1031.4	26.9	76.1	39.4	408.9	480.1
2011	4554	15886	1180.7	28.7	85	44.5	464.1	558.3
2012	4593	16071	1301.7	30.2	94.1	49.1	518.8	609.5
2013	4716	16361	1486.4	31.6	105.5	58	598.1	693.2
2014	4824	16401	1655.1	33.6	119.2	63.9	676.4	762.1
2015	5020	16371	1767.7	34.8	129.8	68.2	736.5	798.5
2016	5141	13470	1752.9	37.7	118.7	63.0	758.4	775.2
2017	5201	16929	1971.1	39.6	131.5	70.9	846.9	882.2

Хүснэгт 6. Иргэдийн хувийн малын бүлэглэлт 2015,2016, 2017 он


	Малтай өрхийн тоо			Нийт өрхийн тоо			Малын тоо, мян.тол		
	2015	2016	2017	2015	2016	2017	2015	2016	2017
Бүгд	5020	5141	5201	100.0	100.0	100.0	1767.7	1724.7	1971.2
10 хүртэл малтай	106	121	87	2.1	2.4	1.7	0.6	0.7	0.6
11-30 хүртэл малтай	293	331	278	5.8	6.4	5.3	6.2	7.0	5.9
31-50 хүртэл малтай	295	300	276	5.9	5.8	5.3	12.2	12.2	11.3
51-100 хүртэл малтай	615	653	556	12.3	12.7	10.7	45.7	48.9	41.8
101-200 хүртэл малтай	899	973	948	17.9	18.9	18.2	132.6	144.2	140.1
201-500 хүртэл малтай	1567	1569	1638	31.2	30.5	31.5	514.8	515.9	546.4
501-999 хүртэл малтай	907	880	1004	18.1	17.1	19.3	616.9	596.8	687.2
1000-1499 хүртэл малтай	276	263	338	5.5	5.1	6.5	323.4	304.4	396.0
1500-2000 хүртэл малтай	45	38	56	0.9	0.7	1.1	75.8	63.9	93.7
2001-с дээш малтай	17	13	20	0.3	0.3	0.4	39.4	30.7	48.2

Малтай нийт өрхийн 23.0 хувь нь 100 хүртэл малтай, 49.7 хувь нь 101-500 хүртэл малтай, 19.3 хувь нь 501-999 хүртэл малтай өрх эзэлж байгаа бол үлдсэн 8.0 хувийг нь 1000-аас дээш малтай өрх эзэлж байна. 1500-2000 хүртэл малтай өрх 56, 2000 дээш малтай өрх 20 байна. 100-аас дээш малтай өрхийн тоо 2017 онд 4004 болж урьд оноос 7.1 хувиар буюу 268 өрхөөр нэмэгдэж, 100 хүртэл малтай өрх 14.8 хувиар буюу 208 өрхөөр буурсан байна.

Зураг 3. 200 хүртлэх малтай өрхийн тоо.



Зураг 4. 1000-аас дээш малтай өрхийн тоо.



II.2. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн


II.2.1 Малын тоо

Нийт мал сүргийн тоо 2010-2017 онд жилд дунджаар 9.3 хувиар өссөөр, 2017 оны жилийн эцэст малын тоо 2001.6 мянган толгойд хүрсэн байна. Нийт малын тоо өмнөх оноос 14.2 хувь буюу 248.7 мянган толгойгоор өссөн. Мал сүргийн тоо таван төрөл дотор тэмээ 7.9 хувь, адуу 12.2 хувь, хонь 13.6 хувь, үхэр 15.2 хувь, ямаа 15.3 хувиар тус тус өссөн байна.


Хүснэгт 7. Малын тоо /мян.тол /

	2014	2015	2016	2017	2017/2016	
					Хувь	зөрүү
Бодоор	450.4	482.4	461.5	522.2	113.2	60.7
Толгойн тоо	1686.8	1801.2	1752.9	2001.6	114.2	248.7
Тэмээ	34.8	36.1	37.7	40.7	108.0	3
Адуу	120.8	131.6	118.7	133.2	112.2	14.5
Үхэр	65.4	69.9	63	72.6	115.2	9.6
Хонь	690.7	751.4	758.4	861.5	113.6	103.1
Ямаа	775	812.2	775.2	893.6	115.3	118.4

Зураг 5. Нэг саяас дээш мал тоолуулсан он, малын тоо, мянган толгойгоор




Зураг 6. Малын тоо, мянган толгойгоор /1991-2017 он /




Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл ихээхэн нөлөөлж байсан байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсаны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч, 2001, 2002, 2006, 2010, 2016 оны өвөл-хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан байна. Энэ хандлага тэмээнээс бусад 4 төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй хонь, ямаа хурдан өссөн байна. Харин тэмээн сүргийн хувьд 1990 оноос хойш буурч, 1995-2008 он хүртэл тогтвортой байсан бол 2009 оноос бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлага байна.

Зураг 7. Аймгийн нийт малд сумдын эзлэх хувь /2017 он/



Зураг 8. Нийт малын тоо.




Хүснэгт 8. Сумдын нийт малын тоо, мянган толгойгоор

	2014	2015	2016	2017	2017 2016
Айраг	134.3	143	124	148.4	119.7
Алтанширээ	111.1	120	113.1	127.2	112.5
Даланжаргалан	145.8	158.2	154.4	174.7	113.1
Дэлгэрэх	180.5	186.9	170.1	186.2	109.5
Иххэт	124	134.6	139.7	167.2	119.7
Мандах	113.5	113.7	132.2	154.0	116.5
Өргөн	112.8	127.6	113.9	128.3	112.6
Сайхандулаан	123.2	138.7	145.0	164.8	113.6
Улаанбадрах	121.4	125.6	121.6	138.6	114.0
Хатанбулаг	196.9	196.1	201.3	228.4	113.5
Хөвсгөл	116	118.5	104.9	121.7	116.0
Эрдэнэ	94.7	114.1	113.0	125.6	111.2
Сайншанд	85.1	96	94.9	109.6	115.5
Замын-үүд	27.5	28.2	25.1	26.9	107.2
ДҮН	1687	1801.2	1753.2	2001.6	114.2

II.2.2 Нийт сүргийн бүтэц

Нийт малын 87.7 хувийг бог мал 12.3 хувийг бод мал эзэлж байна. Мал сүргийн бүтцэд ямаа 44.6 хувь, хонь 43.0 хувь, үхэр 3.6 хувь, адуу 6.7 хувь, тэмээ 2.0 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 9. Мал сүргийн бүтэц хувиар, таван төрлөөр /1970-2017 он/



Хүснэгт 9. Сүргийн насны ангилалын бүтэц /хувиар /

	Төл, өсвөр насны мал				2017-2016	Нас гүйцсэн эр				2017-2016
	2014	2015	2016	2017		2014	2015	2016	2017	
Бүгд	33.0	32.7	30.0	33.1	3.1	23.3	23.5	25.4	23.7	-1.7
Тэмээ	43.8	44.3	44.5	44.5	0.0	15.4	15	14.8	14.7	-0.1
Адуу	43.4	43.1	38.9	40.4	1.5	22	22	24.2	22.3	-1.9
Үхэр	50.4	49.1	46.8	47.4	0.6	8.5	9.2	10.7	10.3	-0.4
Хонь	33.7	33.7	31.9	33.8	1.9	20.9	20.9	22.3	21.4	-0.9
Ямаа	28.9	28.2	24.6	29.7	5.1	27.3	27.7	30.4	27.6	-2.8

Хөдөө аж ахуйн судалгаа - 2017

	Хээлтэгч				2017- 2016	Хээлтүүлэгч				2017- 2016
	2014	2015	2016	2017		2014	2015	2016	2017	
Бүгд	42.9	43.7	43.7	42.3	-1.4	0.9	0.9	0.9	0.9	0.0
Тэмээ	39.3	39.3	39.5	39.8	0.3	1.3	1.3	1.2	1.2	0.0
Адуу	30.6	30.6	32.1	32.5	0.4	4.4	4.4	4.9	4.7	-0.2
Үхэр	40.4	40.4	41.3	40.8	-0.5	1.3	1.3	1.3	1.5	0.2
Хонь	44.8	44.8	45.1	44.1	-1.0	0.6	0.6	0.7	0.7	0.0
Ямаа	43.6	43.6	44.5	42.2	-2.3	0.5	0.5	0.5	0.5	0.0

Хүснэгт 10. Сумдын мал сүргийн бүтэц, хонин толгойд шилжүүлсэн хувиар

Сум	Бүх хонин толгой, мянга	Үүнээс хувиар: тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Айраг сум	216.6	5.3	61.5	20.7	76.1	53.0
Алтанширээ сум	195.6	3.0	57.9	25.1	68.2	41.4
Даланжаргалан сум	252.2	3.8	61.9	34.0	89.5	62.9
Дэлгэрэх сум	310.1	5.9	103.8	44.2	96.9	59.3
Иххэт сум	266.4	1.0	77.3	46.3	83.8	58.0
Мандах сум	235.8	35.9	55.3	16.7	52.9	75.0
Өргөн сум	205.7	6.7	56.2	35.0	60.2	47.6
Сайхан дулаан сум	266.7	22.2	75.7	32.3	68.4	68.2
Улаанбадрах сум	244.6	24.4	75.1	34.3	51.8	59.0
Хатанбулаг сум	373.1	37.1	91.8	58.5	74.0	111.7
Хөвсгөл сум	200.8	23.7	58.0	20.3	40.0	58.7
Эрдэнэ сум	238.4	14.4	87.9	37.9	47.4	50.8
Сайншанд сум	180.4	15.7	53.7	20.9	43.7	46.5
Замын-үүд сум	51.3	4.6	16.4	9.6	8.7	11.9

II.2.4 Хээлтэгч мал

Аймгийн дүнгээр 2017 оны эцэст 846.0 мянган хээлтэгч тоологдсон нь урьд оныхоос 79.9 мянган толгойгоор өссөн байна. Өмнөх оны мөн үеэс ингэ 8.7 хувиар, эм ямаа 9.3 хувиар, эм хонь 11.1, гүү 13.7 хувь, үнээ 14.0 хувь, хувиар тус тус өсчээ.

Хүснэгт 11. Хээлтэгч малын тоо

	2014	2015	2016	2017	Өсөлт, бууралт	
					%	тоогоор
Бүгд	721439	773191	766128	846038	110.4	79910
Ингэ	13745	40221	14896	16197	108.7	1301
Гүү	36458	28249	38048	43264	113.7	5216
Үнээ	26037	14194	25994	29645	114.0	3651
Эм хонь	309340	336517	342359	380201	111.1	37842
Эм ямаа	335859	354010	344831	376731	109.3	31900


II.2.5 Төл бойжилт

2017 оны эхэнд тоологдсон хээлтэгчийн 83.9 хувь буюу 642.9 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.7 хувь буюу 655.3 мянган төл бойжжээ. Бойжуулсан төлийн тоо өмнөх оныхоос 139.0 мянгаар буюу 26.9 хувиар өссөн байна. Гарсан ботгоны 98.7 хувийг, унаганы 99.7 хувийг, тугалны 99.8 хувь хурганы 99.6 хувь, ишигний 99.7 хувийг бойжуулжээ. Төлөлвөл зохих 100 хээлтэгч мал тутмаас 86 төлийг бойжуулсан нь өмнөх онтой харьцуулахад 19-оор илүү байна.

Хүснэгт 12.Төл бойжилт, мянган толгойгоор

	2014	2015	2016	2017	Үүнээс				
					Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	545.4	579.4	555.3	657.5	8.0	30.5	23.2	309.1	286.7
Хорогдсон төл	1.9	7.9	39.0	2.2	0.05	0.05	0.04	1.2	0.9
Бойжсон төл	543.5	571.5	516.3	655.3	7.9	30.4	23.2	307.9	285.8
Бойжилтын хувь	99.6	98.6	93.0	99.7	98.7	99.7	99.8	99.6	99.7

Зураг 10. Бойжуулсан төл, мянган толгойгоор



Хүснэгт 13. 100 эхээс бойжуулсан төл, тоогоор

	2014	2015	2016	2017	Өсөлт, бууралт	
					%	Тоогоор
Бүгд	86	79	67	86	128.3	19
Ботго	55	50	51	54	105.9	3
Унага	83	73	48	80	166.7	32
Тугал	91	85	65	90	138.5	25
Хурга	91	85	76	90	118.4	14
Ишиг	83	75	61	83	136.1	22


II.2.6 Том малын зүй бус хорогдол

Оны эхний малын 5.6 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 112.3 мянган толгойгоор бага мал хорогдсон байна. Нийт хорогдолтын 33.4 хувийг ямаа, 51.8 хувийг хонь, 7.6 хувийг үхэр, 4.4 хувийг адуу, 2.8 хувийг тэмээ эзэлж байна.

Хүснэгт 14. Том малын зүй бусын хорогдол, тоогоор

	2014	2015	2016	2017	Өсөлт, бууралт	
					%	Тоогоор
Бүгд	7327	14416	117960	5637	4.7	-112323
Тэмээ	206	228	300	157	52.3	-143
Адуу	379	489	11330	251	2.2	-11079
Үхэр	1205	581	7420	428	5.7	-6992
Хонь	2533	5419	38630	2918	7.5	-35712
Ямаа	3004	7699	60280	1883	3.2	-58397

Зураг 11. Том малын зүй бус хорогдол, мянган толгойгоор



Хүснэгт 15. Оны эхний малд зүй бусын хорогдлын эзлэх хувь

	2014	2015	2016	2017	2017-2016
Бүгд	0.5	0.9	6.6	0.3	-6.3
Тэмээ	0.6	0.7	0.9	0.5	-0.4
Адуу	0.4	0.4	8.6	0.3	-8.3
Үхэр	2	0.9	10.6	0.6	-10
Хонь	0.4	0.8	5.1	0.4	-4.7
Ямаа	0.4	1	7.4	0.3	-7.1


II.2.7 Малын хээл хаялт, сувайралт

Оны эхний хээлтэгч малын 12.4 хувь буюу 104.9 мянган эх мал хээл хаяж, сувайрсан байна. 2016 онтой харьцуулахад хээл хаясан малын тоо 25.1 мянган толгойгоор, сувайрсан малын тоо 11.8 мянган толгойгоор буурсан байна. Нийт хээл хаясан малын 49.8 хувийг, сувайрсан малын 55.3 хувийг эм ямаа эзэлж байна.

Хүснэгт 16. Хээл хаясан болон сувайрсан эх малын тоо

	Хээл хаясан эх малын тоо				Сувайрсан эх малын тоо			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Бүгд	2737	8297	32422	7311	74474	102102	109336	97575
Ингэ	8	35	17	24	160	265	108	207
Гүү	154	347	3383	445	5453	7804	9330	6901
Үнээ	57	107	1003	214	2414	3192	4358	3410
Эм хонь	994	995	8821	2990	25476	32949	34842	33017
Эм ямаа	1524	6813	19198	3638	40911	57892	60698	54040

Зураг 12. Малын хээл хаялт, сувайралт



Хүснэгт 17. Нийт хээлтэгчид хээл хаяж,сувайрсан эх малын эзлэх хувь

	Хээл хаясан				Сувайрсан			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Бүгд	0.4	1.2	4.2	0.9	10.3	13.2	14.3	11.5
Ингэ	0.1	0.3	0.1	0.1	1.2	0.7	0.7	1.3
Гүү	0.5	1.0	8.9	1.0	15.0	27.6	24.5	16.0
Үнээ	0.2	0.4	3.9	0.7	9.3	22.5	16.8	11.5
Эм хонь	0.4	0.3	2.6	0.8	8.2	9.8	10.2	8.7
Эм ямаа	0.5	1.9	5.6	1.0	12.2	16.4	17.6	14.3

II.2.8 Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормын байгаа боловч бог малын хувьд тохироо алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог мал нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ноогдох байхад аймгийн дундажаар 64 эм хонь, 77 эм ямаа ногдож байгаа нь өндөр үзүүлэлт юм. Өмнөх онтой харьцуулахад хээлтүүлэгчийн тоо 2713 толгойгоор буюу 16.5 хувиар, шинээр тавьсан хээлтүүлэгчийн тоо 43 толгойгоор тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 18. Хээлтүүлэгч малын тоо

	Бүгд				2017 2016	Үүнээс шинээр тавьсан хээлтүүлэгч			
	2014	2015	2016	2017		2014	2015	2016	2017
Бүгд	13596	14972	15962	18595	116.5	92	47	43	86
Буур	436	448	466	502	107.7	0	3	0	1
Азарга	4743	5322	5727	6213	108.5	17	9	5	16
Бух	777	836	915	1061	116.0	4	1	2	10
Хуц	4005	4407	4781	5920	123.8	44	21	15	30
Ухна	3635	3959	4073	4899	120.3	27	13	21	29

Хүснэгт 19. Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо

	Үржлийн норм	2014	2015	2016	2017	2017- 2016
Ингэ	20-25	31	29	32	32	100
Гүү	15-Дес	7	6	7	7	100
Үнээ	34-45	31	28	32	27	84.4
Эм хонь	25-30	70	65	68	64	94.1
Эм ямаа	25-30	85	82	90	77	85.6

II.2.9 Малын хэрэглээний зарлага

Хүснэгт 20. Малын нийт хэрэглээний зарлага /мян.тол/

	2014	2015	2016	2017	2017 2016
Бүгд	284.6	348.2	363.9	368.2	101.2
Тэмээ	3.9	3.9	4.1	4.4	107.3
Адуу	10.9	13.7	17.2	16.9	98.3
Үхэр	11.2	15	15.7	14.2	90.4
Хонь	126.9	159.5	178.8	182.3	101.9
Ямаа	131.7	156.1	148.2	150.5	101.6

Оны эхний малын 21.0 хувь буюу 368.2 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан нь 2016 оныхоос 4.3 мянган толгойгоор буюу 1.2 хувиар их мал хэрэглээнд зарцуулсан байна. Хэрэглээнд зарцуулсан малын 9.6 хувийг бод мал эзэлж, 90.4 хувийг бог мал эзэлж байгаагаас оны эхний тэмээний 11.7 хувь, адууны 14.2 хувь, үхрийн 22.5 хувь, хонины 24.0 хувь, ямааны 19.4 хувийг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хүснэгт 21. Хэрэглээний мал оны эхний малд эзлэх хувь

	2014	2015	2016	2017
Бүгд	18.8	20.6	20.2	21.0
Тэмээ	11.9	11.2	11.4	11.7
Адуу	10.2	11.3	13.1	14.2
Үхэр	18.9	22.9	22.4	22.5
Хонь	20.7	23.1	23.8	24.0
Ямаа	18.7	20.1	18.2	19.4

Хүснэгт 22. Хэрэглээний малын тоо /мян.тол/

	Зэх зээлд борлуулсан			Хүнсэнд хэрэглэсэн			Бусад *		
	2015	2016	2017	2015	2016	2017	2015	2016	2017
Бүгд	221.2	236.6	241.5	126.9	127.4	126.7	94.6	54.2	3.7
Тэмээ	2.8	2.9	3.2	1.1	1.2	1.2	1.8	2.0	0.2
Адуу	10.1	13.1	13.2	3.6	4.1	3.7	2.1	1.1	0.4
Үхэр	9.6	10.0	8.8	5.4	5.7	5.4	1.5	0.6	0.2
Хонь	102.3	119.4	122.4	57.2	59.4	59.9	38.8	20.1	1.6
Ямаа	96.5	91.2	93.9	59.6	57.0	56.6	50.4	30.4	1.4

Хэрэглээнд зарцуурсан малын 65.6 хувийг зах зээлд худалдан борлуулж, 34.4 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулжээ. Малтай 1 өрх дундажаар 46 толгой малыг зах зээлд борлуулж, 24 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна. Бусдад худалдсан, худалдан авсан, шилжүүлсэн мал өмнөх оноос 28.8 мянган толгойгоор буурсан байна.

II.3. Тэжээвэр амьтад

2017 онд 240 гахай, 1608 шувуу тоологдсон нь 2016 оныхоос 71-аар өсч, шувуу 455-аар буурсан байна.

Хүснэгт 23. Тэжээвэр амьтдын тоо

	2013	2014	2015	2016	2017	2017-2016
Гахай	87	121	84	169	240	142.0
Шувуу	565	953	1153	2063	1608	77.9
Гахайтай өрхийн тоо	8	17	11	17	14	82.4
Шувуутай өрхийн тоо	10	5	19	25	22	88.0
Үйлдвэрлэсэн гахайн мах /тн/	1.1	0.4	0.2	1.2	0.3	25.0
Үйлдвэрлэсэн өндөг /мян.ш/	31.7	10.5	19.2	166.9	80.8	48.4

II.4. Малжуулалтын талаарх мэдээлэл

